

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 9 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 9 сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Есдүгээр сард 273 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 24 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 133 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 9 дүгээр сарын байдлаар шинээр төрсөн -5, үүнээс эрэгтэй – 2, эмэгтэй-3, үрчилсний бүртгэл-1, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 1 тус тус бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Төсөвт байгууллагууд батлагдсан тасвийн хүрээнд цалин нийгмийн даатгалын шимтгэл, бусад бараа үйлчилгээий зардлыг хийж гүйцэтгэж байна. Орон нутгийн орлого, нэр төрлөөр биелээгүй ч нийт дүнгээр 117 хувиар биелэсэн. Одоогоор өр авлага үүсээгүй.

Худалдан авах ажиллагааны талаар

- Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгоод гэрээг байгуулсан.
- Жавхлантын багт 1500 м ЦДАШ-ын тендерийг 2 удаа зарлаж нэгч компани ороогүй тул дахин зарлаж 3 компани орсон байгаа ба тендерийн хорооны хурлаар шийдвэрлэнэ.
- Сургуулийн дотуур байр шинээр ашиглалтанд орж цэвэр усныг 10,0 сая төгрөгөөр хийх гэрээ байгуулан ажиллаж байна.
- Шинээр Соёлын төвийн барилга баригдаж байгаатай холбогдуулан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг ярилцаж байна.

Бусад ажил

- Байгууллагад коронавирус халдварт өвчин гарч байгаа учир цахимаар ажлаа хийх зэрэг ажлууд хийгдэж байна.
- Сумын онцгой комиссоос ЭМТ-д 3,0 сая төгрөгийн халдвар хамгааллын хувцас оношлуур зэргийг олгоод байна.

- Санхүүгийн албаны ажлын чиг үүрэгт өөрчлөлт гарч Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч нарын ажлыг хүлээлцүүлэх, архивын баримт материалыг жагсаалтын дагуу хүлээлгэж өгөх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоосон Засгийн газрын 2021 оны 262 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 15-ныг хүртэл хугацаанд иргэдийн газар өмчлөх өргөдлийг хүлээн авсан. Мөн Засаг даргын захирамж гарган Засаг даргын орлогчоор ахлуулсан 4 гишүүнтэй ажлын хэсэг байгуулан нийт 28 өргөдөл ирүүлснээс 22 өргөдлийг шийдвэрлэсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Малын үржүүлэг, бүртгэлийн чиглэлээр:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөө гаргав. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас өөрт хамааралтай бүх ажлуудыг хийж дуусгав. Тоон мэдээллүүд дээр үндэслэн зохих албан тушаалтнуудад зөвлөгөө өгч, яаралтай авч хэрэгжүүлэх ажлын санал хүргүүлэв. Хавсралтыг экселийн файлаар хавсаргав.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын Ургамал хорио цээрийн байцаагч Н.Соёлцэцэгийн зөвлөгөө болох Шинэ ургацын ногоо, хадланд гарсан иргэд, ААН-үүд бараа бүтээгдэхүүнээ борлуулахдаа заавал гарал үүслийн гэрчилгээтэй байх ёстой гэснийг тариалан эрхэлдэг 9 иргэн, 1 аж ахуйн нэгж, байгууллага, хадланд гарсан 2 иргэнд цаг алдалгүй мэдээ, мэдээллээр хүргэв. Мөн ХАА-н мэргэжилтэнтэй хамтран сумын бүх аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангав.

Үржлийн малыг ангилан ялгах бүртгэлжүүлэн цөм сүрэг бүрдүүлэх ажлын хүрээнд аймагтаа анхдагч сум болж ХААГ-н мэргэжилтэнүүдтэй хамтран Дэлгэр багийн Базарханд малчны үхэр-8 толгой, хонь-75 толгой, ямаа-48 толгой малд ангилан ялгалт, ээмэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж сумынхаа мэргэжилтэнүүд болон багийн засаг дарга нарт практик сургалт зохион байгуулав.

ХАА-10 мэдээг 8 сараас эхлэн тогтмол илгээж байна. Сумын хэмээнд төмс- 2,9 тн, лууван0,6 тн, сонгино-1,210 тн, өргөст хэмх- 0,93 тн, улаан лооль- 0,43 тн тус хураагдаад байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний нөөцийн мэдээг ХХААГ-т долоо хоногийн Даваа, Пүрэв гарагт хүргүүлдэг. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 9 сарын 20-ны өдрийн байдлаар:

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	16 тн
Гурилан бүтээгдэхүүн	348 ш
Будаа	265 кг
Хуурай/Шингэн сүү	350ш
Өндөг	500ш
Ургамлын тос	246ш
Төмс	340кг
Хүнсний ногоо	115кг
Элсэн чихэр	370кг
Давс	337кг
Савласан ус	292ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, хүнсний бүтээгдэхүүний татан авалт, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг цаасаар болон цахимаар хүргэн ажиллалаа.

Шатахуун түлшний нөөцийн хувьд хэвийн хомсдол үүсээгүй.

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	16 тн	18 тн	9 тн

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 7-9 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 7 сарын 19 байдлаар	2021 оны 9 сарын 16 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	37000	36000-37000
		Дорнод 2-р зэрэг	29500	29500
2	Цагаан будаа		2700-3000	2700-3000
3	Шингэн сүү		3500-3700	3500-3700

4	Хуурай сүү		5000-10500	5000-11000
5	Элсэн чихэр		2500-2800	2600-3000
6	Ургамлын тос		4800-5500	5500-6300
7	Өндөг		550-700	500-600
8	Төмс		1500	1000-1200
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	3000-3500
		Байцаа	2500-3000	1800-2000
		Лууван	2200	2000
		Сармис	2500	2500
10	Давс		1000-1500	1000-2300
11	Савласан ус		800-3500	900-3500

Мэргэжлийн хяналтаас өгсөн чиглэлийн дагуу хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, түгээлт, тээвэрлэлт, хоол үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, зөрчил дутагдлыг зогсоох үүрэг даалгаврыг авч, хэрэгжүүлэн зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

2021 оны 9 сарын 7-ны өдрөөс эхлэн хүнс худалдаа, хоол үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг 10 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 7 хоногийн Мягмар, Пүрэв гарагт тогтмол хяналт шалгалт хийж, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн, хавсралт хүснэгтийн дагуу зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах улсын онцгой комиссын гаргасан 41-р түр журмын дагуу хүнс худалдаа, хоол үйлчилгээ явуулдаг зарим газруудад “түр тусгаарлах өрөө”-г бэлтгэж эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл, хамгаалах хувцас хэрэгсэл, (амны хаалт, нэг удаагийн халаад, бээлий, улавч, нүдний шил, малгай) асуумж хуудас, халдваргүйжүүлэгч зэрэг шаардлагатай хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн түр тусгаарлах өрөөний бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2021 оны 9 сарын 20-ны өдрийн А/132 дугаар захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 09 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл сумын нутаг дэвсгэрт хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоож, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийн хугацаанд спиртийн өндөр агууламж /18 градусаас дээш/ бүхий архи согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон учир, Тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнийг лацдах арга хэмжээг хэсгийн цагдаа Э.Хатантөмөртэй хамтран явууллаа.

- Тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуйн нэгжийн нийт 1187 бүтээгдэхүүнийг лацадсан.
- Хүнс, бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт үүрэг болгон хяналт тавин ажиллаж байна.
- Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нөөцийг авч, иргэн айл өрхөд хүнс болон эмийн сангийн үйлчилгээг хүргэлтээр хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээг 5 аж ахуйн нэгжүүд халдвар хамгааллын дэглэмийг сахин, зайнаас харьцан үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Сүм хөгжүүлэх сангийн чиглэлээр:

2021.09.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 252,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

Зээлийн хэлбэр	Зээлдэгч	Зээлийн дүн
Хэвийн зээл	10 зээлдэгч	70,000,000
Эргэлзээтэй зээлтэй	/181-360хоног/ 5 зээлдэгч	47,000.000
Муу буюу чанаргүй зээлтэй	/360≥/ - 15 зээлдэгч	131,800,000
Хаагдсан зээл	7 зээлдэгч	48,287,470,

Сүм хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 73,4 % байна.

8 сарын 30 байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 609677 төгрөг сүм хөгжүүлэх санд орж ирсэн байна.

Зээл хаагдсан 3 зээлдэгчид

Зээл авсан он		Зээлдэгч	Зээлийн дүн
1	2011.01.08	Ц.Эрдэнэмөнх	6,833.000
2	2013.04.01	Г.Мөнхтулга	2,000,000
3	2013.04.01	Г.Галбадрах	7,000,000

2.1.2. Эргэн төлөлт хийхгүй байгаа зээлдэгч:

Зээл авсан он	Зээлдэгч	Зээлийн дүн
---------------	----------	-------------

1	2019.05.25	Л.Мөнхнаст	9,000,000
2	2020.5.27	Э.Эрдэнэтуяа	5,000,000
3	2020.05.27	А.Отгонхүү	8,000,000
4	2020.5.27	Т.Чулуун	15,000,000

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэх 1 зээлдэгчид:

2016 онд зээл авсан - С.Шарав

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор мөн зээлийн хугацаа дууссан иргэдэд мэдэгдэл хүргэн ажиллалаа.

Мал эмнэлгийн чиглэлээр:

2021 оны 09 сарын 07 нд баян багийн нутагт шинээр баригдаж байгаа угааллагын ванн барих ажлын явцтайтанилцаж, хяналт хийхээр багийн иргэд нийтийн хурлын дарга, малын эмч, мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Угаалгын ванны нүх доторлогооны ажил хийгдсэн байсан бөгөөд эдгээр ажлын гүйцэтгэл сайн байна гэж дүгнэсэн. Мал угаалгын ванны төмөр хашааг өөр барилгын групп ирж барих юм байна.

2021 оны 09 сарын 12 нд аймгийн Мал эмнэлгийн газар, газрын лабораториос хээлтүүлэгч малын бруцеллёзын шинжилгээний хэрэглэгдэхүүн, дуутын вакцины дутууг татан авч хувийн мал эмнэлгүүдэд хувиарласан.

Малын гоц халдварт шүлхий өвчний тарилгыг зохион байгуулахад сумын Засаг даргын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн А/95 тоот захирамж гарган сумын хэмжээний өвчлөмтгий бүх малд тарьж тарилгын ажлын гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэж аймгийн мал эмнэлгийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Мөн бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг сумын хэмжээний охин төлд хийгдэж дууссан. Аймгийн мал эмнэлгийн газарт мэдээг урьдчилсан байдлаар өгөөд байна.

2021 оны шимэгтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээ хийгдэж байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ариутгал халдваргүйтгэлийн улирлын мэдээ тайланг аймгийн мал эмнэлгийн газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2021 оны 09 сарын 14 нд Мал эмнэлгийн ерөнхий газраас зохион байгуулсан мал эмнэлгийн хянан баталгаажуулалтын цахим сургалт, мөн 2021 оны 09 сарын 23 нд зохион байгуулагдсан малын эмийн хэрэглээний талаархи цахим сургалтуудад тус тус хамрагдсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгчаар бүртгэсэн 10 иргэнийг сэргээсэн. Шинэ ажлын байранд 5 иргэн , зуучлагдсан 15 иргэнийг шинээр бүртгэсэн. Аймгийн хэмжээнд анх удаа зохион байгуулж байгаа Хөдөлмөр эрхлэлтийн зургаан том судалгааг цаг хугацаанд хийж явуулсан.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

2021 оны 09 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд жирэмсэн эхийн тэтгэмжинд 4 иргэн, цалинтай эхийн тэтгэмжинд 2 иргэнийг бүртгэсэн. Мөн цалинтай аавд 5 иргэн, Асаргааны 4 иргэний материалыг хүлээн авсан. Ахмад настны хиймэл шүд, рашаан сувилалын 10 материалыг шивсэн. Хоёр нас барсан иргэний оршууллаганы тэтгэмжийг шийдсэн. Хүнсний талоны 34 өрхөөс 28 өрхийн хүнс тэжээлийг олгосон. Шинээр төрсөн 3 хүүхдийн бичиг баримтыг хүлээн авч бүртгэсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 391382.5 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -331034.5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 48010.8 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 12355.0 мян төг орлоо.

Хэлтсээс 1035000.0 мян төгрөгийн санхүүжилт авч 450 тэтгэвэр авагчдад 1466075.7 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 168 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 48010.8 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 170 даатгуулагчийг даатгаж 12355.0 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -30, тахир дутуугийн тэтгэвэр-5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 37 тэтгэврийг тогтоож, 6 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 11 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоон олгоод байна.

Оршуулгын тэтгэмж 16 тэтгэвэр авагчдад 16000.0 мян төгрөг жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 21 даатгуулагчдад 34373,8 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 5 даатгуулагчдад 329,9 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаандаа төлөөгүй 2 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлсэн.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-38 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-5 , тэтгэмж-43, ажилгүйдлын тэтгэмж-11 малчнаар ажилласан жил тогтоолгох-10 нийт 112

өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 806 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна..

Нийгмийн бодлогын чиглэлээр:

2021 iia nodaaroeua idio 6 iaadae oclodaeeli noaaeaaa Adioee afianidiei nodaaroeua, nodaroeeli yio afianidiea daidaaad 2-5 iaadae oclodaeeli noaaeaaa oclodaeeli oyodyadodon odn odn aadaa aeoo.

Āyđ āꞥ ðꞥōāēēā āyđ āꞥēēēī ðꞥ÷ēðōēēēyŷn ōđūā÷ēēāī nýđāēēēyō òàìòāđñāī āāāēēā ōóđāēāóóēē ēāēēñ øēēāāyđēýēð дээр àæēēēāē āāēīā.

ᠪᠡᠭᠦᠨᠢᠯᠤᠰᠤ ᠲᠤᠶ᠋ᠢᠨᠣᠳᠤᠷ᠎ᠠᠵᠤ ᠬᠤᠯᠠᠭᠠᠨ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠣᠬᠤ ᠠᠯᠪᠠᠨ
тушаалтанд хүргүүлэв. Сумын хэмжээнд боловсролгүй иргэдийн судалгааг гаргаж насан
туршийн боловсролын багшид өгсөн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль эрхзүйн хэлтсээс ирсэн чиглэл хүргүүлэх тухай 2021 оны 08-р сарын 24-ны өдрийн 8/770 тоот албан бичгийн хариуг 9-р сарын 6-ны өдөр тус хэлтэст гаргаж хугацаанд нь хүргүүлэв.

Короновирусын тархалт ихсэж байгаатай холбогдуулан сумын батлагдсан тохиолдлын түргэвчилсэн судалгааг 7 хоног бүр гаргаж аймгийн Гэр бүл,хүүхэд, залуучуудын хөгжлийн газар явуулж байна.

Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 200,000 төгрөгийн санхүүжилтийг өгсөн. Үүний зарцуулалтын тайланг хийж явууллаа. Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн судалгааг гаргаж хүүхдийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж эрсдлийн түвшинг тогтоож ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв:

Үзлэгийн мэдээ 2021 оны 9 дүгээр сарын 24 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1458
2	Амбулаторийн үзлэг	1129
3	Идэвхтэй хяналт	59
4	Гэрийн эргэлт	96

5	Гэрийн дудлага	209
6	Алсын дуудлага	119
7	Артерийн даралт	560
8	Чихрийн шижин	692
9	Хөхний үзлэг	377
10	Эсийн шинжилгээ	58
11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	232
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	1, 2-р тун 3243, Пейзер вакцины 1,2-р тунд 12-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-294, 3-р тунд 254, 2-11 насны томуугийн эсрэг вакцинд 250 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсан тест	1065
14	ПГУ шинжилгээ	327
15	Гэрийн тусгаарлалтад байгаа /ойрын хавьтал/	25
16	Гэрийн эмчилгээнд байгаа	16

Ерөнхий боловсролын сургууль :

- Тус сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 449 суралцагч суралцаж байна.
- Шинэ хичээлийн жилийн босгон дээр ахмад багш БТА Т.Дамдинсүрэн сургуулийнхаа гадна хаягийг /монгол бичиг, крилл, англи хэлээр бичүүлж/ шинэчилж сэтгэлийн бэлэг барьлаа.
- Дэлгэр багийн иргэн Л.Отгонзаяа жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдөр нэг хүүхдэд хичээлийн хэрэглэл бэлэглэсэн нь 4 жилдээ болж байна.
- Багш Б.Оюунжаргал Сүхбаатар аймгийн “Шилдэг багш”-аар шалгарч 3 сая төгрөгөөр шагнуулав.
- Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 75 хүүхдийн ортой дотуур байр шинээр ашиглалтад орж БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 25 сая төгрөгийн гал тогооны иж бүрэн төхөөрөмж, ширээ сандал, хувцасны шүүгээ нийлүүлэгдлээ.
- Дотуур байранд 50 хүүхэд тус байранд амьдарч байна.

- Шинээр ашиглалтад орсон дотуур байранд хүүхэд амьдрах таатай орчин бүрдүүлэхэд эцэг эхийн зүгээс анхаарч одоогийн байдлаар 420,000 төгрөг, 1 бяруу, 2 хонь хандивласан байна.
- Сурагчийн оролцооны байгууллагын сурагчид УИХ-ын гишүүн Ж.Батсуурьт санал тавьснаар нэг ангийн ширээ, сандал /18 ширээ, 36 сандал/ нийлүүлэгдлээ.
- Н.Уранбилэг багштай 86 ангийн сурагчид Түмэнцогт суманд галын аюулд өртсөн айлын хүүхдүүдэд өөрсдийн тусламжаа илгээв.
- “Гүрэн” академаас зохион байгуулж буй “Дэлхийн түвшний монгол багш” хөтөлбөрт онлайн сургалтад нийт 10 багш хамрагдаж байна.
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/292, А/525 дугаар тушаалаар батлагдсан түр журмыг хэрэгжүүлэх зорилгоор захирлын 2021.08.23 өдрийн А/08 тоот тушаалаар коронавируст халдварын тандалт, судалгаа хийх, хариу арга хэмжээ авах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.
- Мобиком Корпарациас зохион байгуулсан "Ухаалаг боловсрол төсөл"-ийн хүрээнд 3 хүүхэд нь ЕБС-д суралцдаг 25 өрхийн 75 сурагч судалгаанд хамрагдлаа. Үүнээс шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд Сүхбаатар аймгийн 219 сурагч оролцсоноос манай сургуулийн 5 сурагч 500000 төгрөгийн үнэтэй М12 гар утас, гарын бэлэг, жилийн хугацаанд ашиглах академик багц, воо багц, facebook ашиглах эрхийн эзэн боллоо. 7а ангийн сурагч А.Мөнхсүх /АУБ А.Сайханцэцэг /, ба ангийн сурагч Б.Түмэн-Өлзий /АУБ Д.Урантуяа, Ж.Мөнх-Од /, 9б ангийн сурагч Сүхболд / АУБ Б.Оюунжаргал /, 5б ангийн сурагч О.Намуунзаяа /АУБ Э.Баасан /, 4а ангийн сурагч Ө.Мөнгөнцэцэг / АУБ Д.Мөнхжаргал /

Хүүхдийн цэцэрлэг:

1. 9-р сарын 1-с цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхэлсэн ба 4-5 настай нийт 96 хүүхэд танхимын сургалтанд хамрагдаж байна.
2. Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журамын хүрээнд “Тандалтын баг”-ийг гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж “төлөвлөгөө”-г боловсруулан эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.
3. Аймгийн нэгдсэн эмнэлэгийн лабораторитай хамтран Цагаан хорхойн шинжилгээг зохион байгуулж нийт 75 хүүхдийг хамруулсан.
4. Өглөөний хүлээн авалт, таралтыг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулж байна.

5. Цэцэрлэгийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшээд байна.
6. Байгууллагын цахим хуудсанд багш нар халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө уриалгыг тогтмол байршуулан ажиллаж байна.
7. Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран “Томуугын эсрэг вакцин”-д нийт 68 хүүхдийг хамрууллаа.
8. Аймгийн БСГ болон бусад албан газруудаас шаардсан баримт бичгийг цаг хугацаанд нь өгч байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Өв залгамжлах эрхийн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан 1 иргэнд шаардагдах материалыг бүрдүүлэхэд хууль зүйн зөвлөгөө мэдээллийн цахим сан E-khutuch.mn-ийг ашиглан хууль зүйн зөвлөгөө өгсөн.

Шинээр томилогдох Соёлын төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчийн хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг авилгалтай тэмцэх газарт 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлж бөгөөд АТГ-аас 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр 05/9026 тоот албан бичгээр хариу илгээж, Засаг даргын захирамжаар Соёлын төвийн эрхлэгчийг түр орлон гүйцэтгэгчээр Н.Юмчинцэцэгийг томилсон.

Засаг даргын 2021 оны захирамжаар ЗДТГ-н дүрмийг баталсан. Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын дагуу Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын цахим мэдээллийн аюулгүй байдлын хангах тухай журам”-ыг ЗДТГ-н даргын А/03 тушаалаар баталж, нийт албан хаагчид дагаж мөрдөж байна.

Тус журмын дагуу байгууллагын сүлжээгээр олон нийтийн сүлжээнд нэвтрэхгүй байх, баримт бичгийг дамжуулахгүй байх, үрэгдүүлэхгүй байхыг зөвлөж, хориглосон. Бид төрийн байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн систем болох ERP системийг ашиглаж эхэлсэн. ЗДТГ-н бүх албан хаагчид албаны цахим шуудантай болж, үүгээр сарын мэдээ, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн А, Б анкетийг бөглөн хувийн хэрэг үүсгэсэн.

Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/132 дугаар захирамж гарган сумын хэмжээнд долоо хоногийн хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоосон.

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг 98514040 дугаарт түргэн шуурхай хүлээн авч, цаг тухайд нь хариу өгч, шийдвэрлэж байна. Өнөөдрийн байдлаар цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Гэрийн тусгаарлалт, ажиглалт буюу эмчилгээнд байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсгээс долоо хоногийн хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийн хугацаанд явган эргүүлэн баг гарган ажиллаж байна. Тус баг нь 5 гишүүнтэй бөгөөд амны хаалт зүүгээгүй иргэнд шаардлага тавих, аж ахуйн нэгж, байгууллагууд амны хаалт зүүгээгүй иргэн болон 0-15 хүртэл бага насны хүүхдэд үйлчилж буй эсэхэд хяналт тавих зорилготой бөгөөд өглөө 08:00 цагаас оройн 18:00 цаг хүртэл ажиллаж байна

Мөн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/133 дугаар захирамж гарган коронавируст халдварын тархалтыг хумих, өвчтөний ойрын болон дам хавьтлыг илрүүлэх ажлыг эрчимүүлэхээр 2 дугаар багийн Засаг даргаар ахлуулсан 7 гишүүнтэй “Тандалтын бүлэг” байгуулж, Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж байна.

2021 оны 9 дүгээр сарын байдлаар Хулгайлах гэмт хэрэг-2, Залилах гэмт хэрэг-1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-4, танхайрах-1 тус тус зөрчил гарсан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ